



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 4/391


Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын
эсрэг вакцинаар дархлаажуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 35 дугаар зүйлийн 35.6, 35.7, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсад хэрэглэж байгаа Пфайзер-БиоН'Тех үйлдвэрийн "Комирнэти" (BNT162b2), АстраЗенека вакцины лицензээр үйлдвэрлэсэн "AZD1222", Синофарм/BBIBP үйлдвэрийн Вероцелл буюу "CorV" вакцинаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтад хамрагдаагүй иргэдийг сайн дурын үндсэн дээр, тархвар судлалын заалтаар, вакцины сонголтыг нь харгалзан вакцинжуулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулах арга хэмжээг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттөр), дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.
3. Дархлаажуулалтын цахим бүртгэлийн програмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Мэдээлэл технологийн хэлтэс (Т.Дашцэрэн)-т, шаардлагатай компьютер бусад тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, вакцинжуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД